

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.040.30

<b>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. Workplace atmospheres. Hygienic requirement.</b>	<b>MNS 4990 : 2000</b>
	<b>УСТ 12.0.13-1991-ийн оронд</b>

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2000 оны 8 -р сарын 31-ны өдрийн 135 тоот тогтоолоор батлав.

Энэхүү стандарт 2000 оны 09-р сарын 01 -нээс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

### 1 Хамрах хүрээ

Энэ стандартаар ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлагыг болон ажлын байрны агаар дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээг тогтооно.

### 2 Эрүүл ахуйн шаардлага

**2.1** Ажлын байрны агаарын температур, чийгшил, хөдөлгөөний хурдын тохиромжтой ба зөвшөөрөх хэмжээг 1-р хүснэгтэд үзүүлэв.

Ажлын бүсийн агаарын цаг уурын  
төхиромжтой ба зөвшөөрөх хэмжээ

1-р

хүснэгт

Жилийн улирал	Ажлын зэрэглэл	Температур			Харьцангуй чийгшил			Хөдөлгөөний хурд м/сек		
		Тохиромжтой хэмжээ	Зөвшөөрөх хэмжээ		Тохиромжтой хэмжээ	Зөвшөөрөх хэмжээ,байнгын ба байнгын	Тохиромжтой хэмжээ (ихгүй)	Зөвшөөрөх хэмжээ,байнгын ба байнгын		
			Байнгын ажлын	Байнгын бус ажлын						
Хүйтний	Хөнгөн-1а	22-24	21-25	18-26	40-60	75	0,1	0,1-ээс ихгүй		
	Хөнгөн-1б	21-23	20-24	17-25	40-60	75	0,1	0,2 - "-		
	Дунд	18-20	17-23	15-24	40-60	75	0,2	0,3 - "-		
	Дунд -2б	17-19	15-21	13-23	40-60	75	0,2	0,4 – "-		
	Хүнд-3	16-18	13-19	12-20	40-60	75	0,2	0,5 – "-		
Дулааны	Хөнгөн – 1а	23-25	22-28	20-30	40-60	28 <sup>0</sup> С-д 55	0,1	0,1-0,2		
	Хөнгөн – 1б	22-24	21-26	19-30	40-60	27 <sup>0</sup> С-д 60	0,2	0,1-0,3		
	Дунд –2а	21-23	18-27	17-29	40-60	26 <sup>0</sup> С-д 65	0,3	0,2-0,4		
	Дунд б	20-22	16-27	15-29	40-60	25 <sup>0</sup> С-д 70	0,3	0,2-0,5		

	Хүнд –3	18-20	15-26	13-28	40-60	24 <sup>0</sup> С ба түүнээс доош 75	0,4	0,2-0,6
--	---------	-------	-------	-------	-------	--	-----	---------

**2.2** Стандартад заасан шаардлага хөргөх ба халаах хэрэгслийн гадаргуугийн температурт хамаарахгүй. Тоног төхөөрөмжийн гадаргуугийн температурыг 45<sup>0</sup>-аас хэтрүүлж болохгүй.

**2.3** Технологийн тоног төхөөрөмжийн халсан гадаргуу, гэрэлтүүлэгч хэрэгслээс гарах дулаан тархалтын чадал, биеийн гадаргууд нөлөөлөх талбайн зөвшөөрөх хэмжээг 2-р хүснэгтэд үзүүлэв.

2-р

хүснэгт

Ажлын биеийн гадаргууд нөлөөлөх талбай, %	Нөлөөлөх дулааны чадал, вт/м <sup>2</sup>
25% хүртэл бол	100
25%-50%	70
50% -иас дээш бол	35

**2.4** Задгай үүсгүүр (халсан металл, шил, задгай дөл г.м )-ийн дулааны тархалтын чадал 140вт/ м<sup>2</sup> –аас хэтрэхгүй байх ба түүний нөлөөнд байх биеийн гадаргуугийн талбай 25%-иас доош байна.

### **3 Агаарын орчны үзүүлэлтийг хэмжих**

**3.1** Ажлын байрны агаарын дулаан, хөдөлгөөний хурд, чийгшлийн үзүүлэлтийг жилийн дулааны ба хүйтний улиралд, 1цэгт гурваас доошгүй удаа хэмжиж дундаж утгыг авна. Ажлын байрны агаарын дулаан, хөдөлгөөний хурд, чийгшлийн үзүүлэлт нь технологийн болон бусад шалтгаанаар хэлбэлздэг учир хэмжилтийг ажлын ээлжийн туршид ажлын их ба бага ачааллын үед явуулна.

**3.2** Хэмжсэн үзүүлэлтийн хэмжээ энэхүү стандартын 1-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

**3.3** Агаарын температур, харьцангуй чийгшил, хөдөлгөөний хурдыг шалнаас дээш суугаа ажлын үед 1 м-ийн өндөрт, зогсоо ажлын үед 1,5 м-ийн өндөрт хэмжинэ.

Байнгын ба байнгын бус ажлын байранд дулаан, чийг, хүйтэн ялгаруулдаг эх үүсгүүр (хаалга, цонх, ил задгай банн, халаах төхөөрөмж зэрэг)-ээс хамгийн ойр ба хамгийн хол зайнд хэмжилт явуулна.

**3.4** Ажлын байрны нягтрал ихтэй, дулаан, хүйтэн ,чийг ялгаруулч үүсгүүр байхгүй, агаар нь жигд тархсан ажлын байранд агаарын температур, харьцангуй чийгшил, хөдөлгөөний хурдыг хэмжих хэсгийн тоог 3-р хүснэгтэд заасны дагуу тогтооно.

Ажлын байрны агаарт хэмжилт хийх тоог  
ажлын талбайд харьцуулан гаргасан тоо

3-р хүснэгт

Үйлдвэрлэлийн байрны талбай м <sup>2</sup>	Хэмжилт хийх хэсгийн тоо (доод хязгаар)
40-100 хүртэл	3
101-400 (400 ороод)	4
400-аас дээш	Хэмжилт хийх хэсгийн хоорондох зай 100 м-ээс ихгүй байна

**3.5** Ажлын байрны өндрөөс хамаарсан агаарын температур, хөдөлгөөний хурдны зөрүүг шалнаас дээш 0,1; 1,0; 1,7м-ийн өндөрт хэмжих замаар тодорхойлно.

**3.6** Дулаан эх үүсгүүрийн дулаан тархалтын чадлыг тодорхойлохдоо хэмжих багажийг төхөөрөмжөөс дулаан тархах чиглэлд перпендикуляраар, шалнаас дээш 0,5; 1,0; 1,5 м-ийн өндөрт байрлуулж, үүсгүүр тус бүрийн дулаан тархалтын хэмжээг хэмжинэ.

**3.7** Хязгаарлах бүтээц (хана, шал, тааз) буюу тоноглол (дэлгэц г.м), технологийн тоног төхөөрөмж болон түүнийг тусгаарлагчийн гадна гадаргуугийн температурыг байнгын ба байнгын бус ажлын байрны агаарын орчныг бүрэн хамруулж хэмжинэ.

**3.8** Агаарын температур, харьцангуй чийгшлийг психрометрээр хэмжинэ. Агаарын температур, харьцангуй чийгшлийг бүтэн хоног буюу долоо хоногоор тасралтгүй хэмжих шаардлагатай үед термограф, гигрограф, термогигрографийн тусламжтайгаар хэмжинэ.

**3.9** Агаарын хөдөлгөөний хурдыг анемометрээр хэмжинэ.

**3.10** Хязгаарлах бүтээц (хана, шал, тааз) буюу тоноглол (экрэн зэрэг), цахилгаан тоног төхөөрөмжийн гадна гадаргуу, тусгаарлах тоноглолын температур, дулаан тархалтыг актинометр, балометр, цахилгаан термометр зэрэг багажаар хэмжинэ.

**3.11** Хэмжих хэрэгслийн хэмжилтийн хязгаар ба зөвшөөрөх хэлбэлзлийг 4-р хүснэгтэд үзүүлэв.

Хэмжих хэрэгслийн хэмжилтийн хязгаар, зөвшөөрөх хязгаар

4-р хүснэгт

Үзүүлэлтийн нэр	Хэмжих хязгаар	Хэмжлийн зөвшөөрөх хэлбэлзэл
Агаарын температур, хуурай термометрийн заалтаар, °С	30-50 (50 ороод)	±0,2
Агаарын температур, нойтон термометрийн заалтаар, °С	0-50	±0,2
Гадаргуугийн температур, °С	0-50	±0,5
Агаарын харьцангуй чийгшил, %	10-90	±5,0
Агаарын хөдөлгөөний хурд, м/с	0-0,5	±0,05
	0-аас дээш	±0,1
	10-350 (350 ороод)	±5,0
Дулааны цацруулалтын эрчим Вт/м <sup>2</sup> ,	350-аас дээш	±50,0

#### 4 Ажлын байрны агаарт хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ

**4.1** Ажлын бүсийн агаарт хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээг 5-р хүснэгтэд заасны дагуу байна.

**4.2** Ажлын бүсийн агаарт хорт бодисын хэмжээ ихсэхээс урьдчилан сэргийлж системтэйгээр хяналт явуулахдаа хорт бодисын 1 удаагийн хамгийн

их хэмжээ, ээлжийн дундаж хэмжээ гэсэн үзүүлэлтээр хэмжинэ.

**4.3** 5-р хүснэгтэд зөвшөөрөх дээд хэмжээг бутархай тоогоор илэрхийлсэн байгаа үед хүртвэрт байгаа тоо нь ажлын байрны агаарт байх хорт бодисын нэг удаагийн хамгийн их зөвшөөрөх дээд хэмжээ, хуваарьт байгаа тоо нь ээлжийн дундаж зөвшөөрөх дээд хэмжээг тус тус заана.

**4.4** Ажлын байрны агаарт өөр өөр төрлийн үйлчилгээтэй хэд хэдэн хорт бодис нэгэн зэрэг агуулагдаж байвал хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээг бодис тус бүрээр тодорхойлно.

**4.5** Ажлын байрны агаарт нэг төрлийн үйлчилгээтэй хэд хэдэн хорт бодис нэгэн зэрэг агуулагдаж байвал хорт бодис тус бүрийн байгаа хэмжээ ( $K_1, K_2 \dots K_n$ ) –г тэдгээрийн зөвшөөрөх дээд хэмжээ ( $A_1, A_2 \dots A_n$ ) -ний харьцааны нийлбэр нэгээс ихгүй байна. Энэ нь дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$\frac{K_1}{A_1} + \frac{K_2}{A_2} + \dots + \frac{K_n}{A_n} < 1$$

## **5 Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжээг тодорхойлох**

**5.1** Агаарт хорт бодис ялгаруулдаг ажлын байранд агаараас шинжилгээний дээжийг авахдаа амьсгалын бүсээс авна.

**5.2** Ажлын бүсийн агаарт ялгарч байгаа бодисыг тухайн хэсэг бүрт тодорхойлно. Хэд хэдэн хорт бодис ялгарч байгаа үед бодис тус бүрийг тодорхойлохоос гадна хамгийн их хортой бодисын тархалтыг тодорхойлно.

**5.3** Нэг төрлийн тоног төхөөрөмжтэй буюу ижил үйл ажиллагаатай үйлдвэрлэлийн байрны дунд ба зах хэсэгт тодорхой ажлын байр (цэг) сонгон авч ажлын ээлжийн туршид ба технологийн тодорхой үе шатанд нэг цэгээс хооронд нь тодорхой зайтай, гурваас доошгүй сорьц авна. Сорвижуулах үйлчилгээтэй тоосонцор байдалтай хорт бодисын тархалтыг тодорхойлоход нэг сорьц авч болно.

**5.4** Өгөгдсөн тодорхой цэгээс сорьц авах нийт хугацаа хорт бодист 15 минут, сорвижуулах үйлчилгээтэй тоосонцор байдалтай хорт бодист 30 минут байна. Заагдсан хугацаанд нэг буюу хооронд нь ижил хугацааны зайтай хэд хэдэн сорьц авч болно. Авсан сорьцын шинжилгээний дүнг (хэрвээ хэд хэдэн сорьц авсан бол дунджийг) зөвшөөрөх дээд хэмжээтэй харьцуулна.

**5.5** Онцгой хорт бодис бүхий ажлын байранд тухайн хорт бодисын ууршилт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд мэдээлэл өгч байх дохиоллын системтэй байна.

**5.6** Хорт бодисын ууршилтанд хяналт тавих хугацааг түүний хорын зэргээс хамааруулан дараах байдлаар тогтооно.

а). Онцгой хортой бодис 10 хоногт 1-ээс доошгүй удаа,

б). Хортой бодисыг сард нэгээс доошгүй удаа,

в). Бага хортой бодисыг улиралд нэгээс доошгүй удаа

**5.7** Үйлдвэрлэлийн ажлын байрны тодорхой нөхцөлөөс шалтгаалан бага хортой бодисын ЗДХ байнга хэвийн байгаа тохиолдолд хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр хяналтын хугацааг өөрчилж болно.

**5.8** Ээлжийн дундаж зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хяналт тавих сорьцыг бодис тус

бүрээр хэд хэдэн удаа хэмжиж хэмжилтийн дундаж дүнг тухайн нөхцөлд ажиллагчдын ажилласан хугацаатай жишиж тодорхойлно.

Хэмжилтийг 3-аас доошгүй ээлжинд ээлжийн ажиллах хугацааны 75-аас доошгүй хувийг хамруулан хийж, дараах илэрхийллээр тооцно.

$$K_{эд} = \frac{K_1 t_1 + K_2 t_2 \dots + K_n t_n}{t_1 + t_2 \dots + t_n};$$

Энд:

$K_{эд}$  – хорт бодисын ээлжийн дундаж хэмжээ, мг/м<sup>3</sup>,

$K_1, K_2 \dots K_n$  – технологийн тодорхой үе шатуудад хэмжсэн хорт бодисын арифметикийн дундаж хэмжээ, мг/м<sup>3</sup>,

$t_1, t_2 \dots t_n$  – технологийн үе шат тус бүрийн үргэлжлэх хугацаа, минут.

## **6 Ажлын бүсийн агаарт байгаа хорт бодисын хэмжээг тодорхойлох аргад тавих шаардлага**

**6.1** Ажлын бүсийн агаарт байгаа хорт бодисын хэмжээг тодорхойлохдоо бодис тус бүрийг шинжлэх аргын батлагдсан стандартыг баримтлан гүйцэтгэнэ.

**6.2** Хорт бодисыг тодорхойлохдоо орчны агаарын температур 293К (20°C), агаарын даралт 101,3КПА (760) мм мөнгөн усны баганы даралтанд оруулж тооцно.

### **Нэр томъёоны тодорхойлолт**

**1** Ажлын байрны агаарын орчинд - Агаарын температур, хөдөлгөөний хурд, чийгшил, дулааны тархалтын үзүүлэлт тус тус хамаарна.

**2** Агаарын орчны тохиромжтой нөхцөл - Ажлын байрны агаарын температур, урсгалын хурд, чийглэг, дулаан тархалтын нөлөөлөл нь хүний биед удаан хугацаагаар болон үе үе нөлөөлөхөд ажилтаны бие махбодийн үйл ажиллагаанд өөрчлөлт орохгүй, хөдөлмөрлөх чадвар байнга өндөр түвшинд байх нөхцөл.

**3** Агаарын орчны зөвшөөрөгдөх нөхцөл - Ажлын байрны агаарын температур, урсгалын хурд, чийглэг, дулаан тархалтын нөлөөлөл нь хүний биед удаан хугацаагаар болон үе үе нөлөөлөхөд ажилтаны бие махбодийн үйл ажиллагаанд өөрчлөлт орж болох боловч тэр нь ажлын дараах амралтын үед сэргэж чадах, ажиллагчдын эрүүл мэндэд гаж нөлөө үзүүлэхгүй байх нөхцөл.

**4** Хүйтний улирал – Гадна агаарын температурын хоногийн дундаж  $-10^{\circ}\text{C}$  ба түүнээс доош байх жилийн улирал.

**5** Дулааны улирал - Гадна агаарын температурын хоногийн дундаж  $+10^{\circ}\text{C}$  ба түүнээс дээш байх жилийн улирал.

**6** Гадна агаарын температурын хоногийн дундаж - Гадна агаарын температурыг хоногийн туршид хооронд нь ижил хугацааны зайтай тодорхой цэгүүдэд хэмжсэн хэмжилтийн нийлбэрийг үйлдвэрлэлийн гар ажиллагаатай дархны цех, хэв цутгах, салгах болон

## **MNS 4990 : 2000**

түүнтэй төстэй ажил мэргэжил хамаарагдана.

**8** Ажлын бүсийн агаарын хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ – Хортой нөхцөлд өдөр бүр (амралтын өдрөөс бусад) 8 цаг хүртэл буюу долоо хоногт 40 цагаас их биш хугацаагаар ажилласан бүх хугацаанд хүний биеийн байдал эрүүл мэндэд тухайн үед болон хожим, үр удамд нь ямар нэг өөрчлөлт оруулж өвчлүүлэхгүй болох нь нотлогдсон хорт бодисын хэмжээ.

**9** Амьсгалын бүс – Ажиллагсадын нүүрний түвшин дэхь 50 см-ийн доторх эргэн тойрныг хамрах орон зай

**ТӨГСӨВ.**

АЖЛЫН БАЙРНЫ АГААРЫН ОРЧИН ДАХЬ  
ХОРТ БОДИСЫН АГУУЛАМЖИЙН ЗӨВШӨӨРӨХ  
ДЭЭД ХЭМЖЭЭ, ХОРЫН АНГИЛАЛ, ТӨЛӨВ БАЙДАЛ, НӨЛӨӨ

5-р хүснэгт

1	Бодисын нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг  м <sup>3</sup>	Хорын зэргийн ангилал	Төлөв байда л	Биед үзүүлэх онцлог нөлөө
1	Азотын исэл	5	х	у	
2	Азотын хоёрч исэл	2	х	у	
3	Азотын хүчил	2	бх	у,а	хү
4	Азот хүчлийн аммони	5	бх	а	
5	Азот хүчлийн бари	0,5	х	а	
6	Азот хүчлийн кали	5	бх	а	
7	Азот хүчлийн зэс	0,5	х	а	
8	Азот хүчлийн хөнгөнцагаан	0,2	х	а	
9	Азот хүчлийн натри	5	бх	а	
10	Азотлог хүчлийн натри	0,05	ох	а	
11	Азот хүчлийн стронци	6	х	а	
12	Азот хүчлийн хартугалга	0,05	х	а	
13	Азот хүчлийн цайр	2	бх	а	
14	Азид натри	0,29	х	а	
15	Адипиний хүчил	4	бх	а	
16	Акролеин	0,2	х	у	
17	Акриламид	0,2	х	а	хү
18	Акрилонитрил	0,5	х	у	хү
19	Акрилийн хүчил	5	бх	у	
20	Алзарин улаан	20	х	у	
21	Алипур	1	х	а	
22	Аллилхлорт	0,3	х	у	хү
23	Аллиламин	0,5	х	у	хү
24	Аллилацетат	2	х	у	хү
25	Аллилцианид	0,3	х	у	хү
26	Альдрин	0,01	ох	у,а	
27	Амиллийн спирт	10	бх	а	хү
28	Аммиак	20	бх	у	
29	Анилин	0,1	х	у	
30	Ацетилин	70	бх	у	
31	Ацетон	200	бх	у	
32	Аминазон	0,3	х	у	
33	п -Аминобензолсульфамид	0,5	х	а	
34	Амилацетат	100	бх	у	
35	Амин хүчлүүд (алинин, валин, глицин, лейзин, лизин, изолейзин метионин, оксипропилин, пролин, серин, трозин, фенилаланин)	5	бх	а	
36	Амилomezинтрин	1	бх	у	

**MNS 4990 : 2000**

37	Амилоформин	10	бх	у	хү
38	Амины алифатик (C <sub>7</sub> -C <sub>9</sub> ), (C <sub>15</sub> -C <sub>20</sub> )	5	бх	у	
39	п-Аминобензотрифтормид	0,5	х	а	
40	α-Аминоантрахинон	5	бх	у	
41	2-(п-Аминобензолсульфамид) 4, 6 диметилпиримидин	1	х	а	
42	2-(п-Аминобензолсульфамид) тиазол	1	х	а	
43	п-Аминобензолсульфанил гуандин	1	х	а	
44	п-Аминобензол сульфацетамид	1	х	а	
45	Аминопластууд	6	бх	а	
46	Ампициллин	0,1	х	а	
47	Амидофос	0,5	бх	а	
48	Анабазин	0,1	х	а	
49	Анизол	10	бх	а	
50	Анитио	0,5	х	а	
51	Атразин	2	бх	а	
52	Ацетилальдегид	5	бх	у	
53	Ацетилсалицилийн хүчил	0,5	х	а	хү
54	Альфанафтамин	0,1	х	а	
55	Аргинин, аспарагины хүчил	10	бх	а	
56	Аминофенол (м, п)	1	х	а	
57	Амидофос	0,5	х	а	
58	Аммофос (моно ба диамины фосфатуудын холимог)	6	бх	а	
59	Ацетофенон	5	бх	у	
60	Ацетонафтен	10	бх	у,а	
61	Барий ба барийн исэл	0,5	х	а	
62	Бутилакрилат	10	бх	у	
63	Барийн ислийн гидрат	0,1	бх	а	сү
64	Барийн хэт исэл	0,1	х	а	сү
65	Бактерийн амилаз	1	х	а	
66	Бенз А-прен	0,00015	ох	а	сү
67	Бензилийн спирт	5	бх	у	сү
68	Бензил пенцилин	0,1	х	а	сү
69	Бензин	100	бх	у	хү
70	Бензол	15/5	х	у	кү
71	Бензидин	0,001	ох	у,а	кү
72	Бензойны хүчил	100	бх	у	
73	Бензилальдегид	5	бх	а	
74	Бензилцианид	0,8	х	у	хү
75	Бензилийн спирт	5	х	у	хү
76	Бензолын нитро нэгдлүүд	3	х	у	
77	Бензо хинон	0,05	ох	у	
78	Бетанол	0,5	х	а	
79	Бор агуулсан нэгдлүүд	10	бх	а	
80	Бор хүчлийн натри	1	х	а	



81	Борын хүчил	10	х	а	
82	Боверин	0,3	х	а	
83	Боксит	6	бх	а	
84	Боракарбид	6	бх	а	
85	Брелий түүний нэгдлүүд	0,001	ох	а	кү
86	Бром	0,5	х	у	
87	Бромт устөрөгч	2	х	у	
88	Бромт бензол	0,3	х	у	
89	Бромфром	1	х	у	
90	Бромт натри	10	бх	а	
91	Бромт кали	5	бх	у	
92	Бутилацетат	200	бх	у	
93	Бутилийн спирт	10	бх	у	
94	Бутилийн эфир	0,5	бх	у	
95	Бутифос	0,2	х	а	
96	Бутан	1900	бх	у	
97	Биовит	0,1	х	а	
98	Бромт амид	0,3	х	у	хү
99	Бороксидын ректификактор	10	бх	а	
100	Бромт гексил	0,3	х	у	
101	Бромт метил	1	ох	у	
102	Бромметилен	0,2	х	а	
103	Бромбензатрон	2	х	у	
104	Бромфенол (о, п)	0,3	х	у,а	
105	1, 3 бутадиен	100	бх	у	
106	3-бутено – лактон	1	ох	у	
107	трет-Бутилперацетат	0,1	ох	у	
108	Бутилийн эфир, акрилийн хүчилтэй	10	бх	у	
109	Бутилкаптакс (2 бутилтиобенз-тиозол)	2	бх	у	
110	Бутилийн эфир, метакрилийн хүчилтэй	30	бх	у	
111	Бутилизотиоцианат	1	х	у	
112	Бутилийн эфир, тосны хүчилтэй (бутилбутират)	20	бх	у	
113	Бутилийн эфир азотлог хүчлийн (бутилнитрит)	1	х	у	
114	Валераны хүчил	5	бх	у	
115	Ванади ба түүний нэгдлүүд	0,1	ох	а	
116	Ванадын гуравч ба тавч ислийн тоос	0,5	х	а	
117	Ваналин	0,5	бх	уа	
118	Винилхлорид	5/1	ох	у	кү
119	Ванади агуулсан шаарны тоос	4	бх	а	
120	Винилацетат	10	бх	у	
121	Винилацетилен	20	бх	у	
122	Винил бутилийн эфир	20	бх	у	
123	Винил пиридин	0,5	х	у	хү
124	Винилоксиэтилметакрилат	20	бх	у	

**MNS 4990 : 2000**

125	Вискоз	5	бх	у	
126	Винил толуол	50	бх	у	
127	Висмут түүний органик биш нэгдлүүд	0,5	х	а	
128	Витаминуудын уурагжуулсан концентраци	0,1	х	а	
129	N-винилпирролидон	1	бх	у	
130	Вольфром түүний органик биш нэгдлүүд	6	бх	а	хү
131	Гексахлорфен	0,1	х	а	хү
132	Галантамин	0,05	ох	у,а	хү
133	Галлийн исэл	3	бх	а	
134	Гексабромбензол	2	бх	а	
135	Гексан	300	бх	у	
136	Гексафторбензол	5	бх	у	
137	Гексаметиленимин	0,5	х	у	хү
138	Гексаметилендиамин	0,1	ох	у	
139	Гексаметилдисилазан	2	бх	у	
140	α-Гексахлоран (гексахлорцикло-гексан)	0,1	ох	у,а	хү
141	β-Гексахлоран (гексахлорциклогек-сан)	0,05	х	у,а	хү
142	Гексахлорбензол	0,9	х	у,а	хү
143	Гексахлорциклопентадиен	0,01	ох	у	хү
144	Гексахлорбутадиен	0,005	ох	у	хү
145	Гептахлор	0,01	ох	у	хү
146	Германий исэл	2	бх	у	
147	Германий ислийн гидрат	5	бх	у	
148	Германи дөрвөн хлорт	1	х	а	
149	Гигромицин	0,001	ох	у	хү
150	Гидразин	0,1	ох	у	
151	Гидрагсиламин	2	бх	у	
152	Гидрохинон	2	бх	а	
153	Гидрохинонт зэс	0,5	х	а	
154	Гидрохинонт хар тугалга	0,005	ох	а	
155	Гидроперекись изопротилбензол	1	х	у	
156	Гидроперекись (3-дагч амиллийн ба бутилийн)	1	х	у	
157	Гидротерфенил	5	бх	у,а	
158	Глинозем	6	бх	а	
159	Глюкавамарин	2	бх	а	
160	Гидратцеллюлозын ширхэлэгт суурилагдсан нүүрс усны ширхлэг тоос	4/2	бх	а	
161	Глутарын диальдегид	5	бх	у	
162	Глифтор	0,05	ох	у	
163	Гуравдагч фосфорын исэл	2	бх	а	
164	Гурван меллилийн хүчлийн ангидрид	0,1	х	а	хү

165	Гурванизопропаноламин	5	бх	у,а	хү
166	Гурванхлорт бутадиен	3	бх	у	хү
167	Гурванхлорт ацетальдегид	5	бх	а	
168	2, 3, 6 гурванхлорт толуол	10	бх	а	
169	Гурванхлорт фтор	0,2	бх	у	
170	Гурванхлорт цууны хүчил	5	бх	у,а	
171	Гурванхлорт пропен	0,1	х	у	хү
172	Гурванхлорт фосфор	0,2	х	у	хү
173	Гурванхлорт метилен (хлорформ)	25	бх	у	
174	Гурванхлорт стирол	5	х	у	
175	Гурванхлорт төмөр	4	бх	а	
176	Давсны хүчил (хлорт устөрөгч)	5	х	у	
177	2, 4 диамины давс	0,3	х	а	
178	Диатомит	1	бх	а	
179	Диаминодифенилоксид	5	бх	а	
180	Диборан	0,1	бх	у	
181	Дезоксипеганин-гидрохлорид	0,5	х	а	хү
182	Дезоксана-3-ын дэгдэмхий бодисууд	1	х	у,а	
183	Декабромидфенилоксид	3	бх	а	
184	Декалин	100	бх	у	
185	Диаллилмин	1	х	а	хү
186	Диалил изофталат	0,5	х	у,а	
187	4, 4 диаминодифенилсульфид	1	х	а	
188	1, 4 диаминодифенилсульфон	5	бх	а	
189	Диамин	2	бх	а	
190	Диангидрид 1, 4, 5, 8 нафталин тетракарбоны хүчил	1	х	а	
191	Диацетоны спирт	100	бх	у	
192	Диалкилфталат (ДАФ-56)	1	х	у,а	
193	Дибутилкетон	2	бх	у	хү
194	Дибутилсебацинат	10	бх	у,а	
195	Дибутилийн эфир, адапины хүчилтэй	5	бх	у,а	
196	Децис	0,1	х	у,а	
197	Диазинон	0,01	х	у,а	сү
198	Дифениламин	10	бх	у,а	
199	Дифенилкарбозид	5	бх	а	
200	Динатрын давс	2	бх	а	
201	Диоксан	10	бх	у	
202	Диметилсульфоксид	20	бх	а	
203	2, 4 динитрофенол	0,05	х	у	
204	Дильдрин	2	бх	у	
205	Дилудин	2	бх	у	
206	Диэтиламин	30	бх	а	
207	Диэтиленгликоль	10	бх	а	
208	Динитробензол	10	х	у,а	
209	Дихлорэтан	400	х	у	
210	Диэтилийн эфир	300	х	у	

**MNS 4990 : 2000**

211	Дөрвөнхлорт титан	0,3	бх	у	
212	Дөрвөнхлорт нүүрстөрөгч	2	бх	у	
213	Дөрвөнэтилт хартугалга	0	ох	у,а	
214	Диметилфталат	0,3	х	у,а	
215	Дөрвөнхлорт этилен	10	бх	у	
216	Дибутилийн эфир	10	бх	у,а	
217	Диборид магни	1	бх	а	
218	Диборидтитан-хром	1	бх	а	
219	Дибромпропан 1, 2	5	бх	а	
220	Дивинилпиридин	1	х	у	хү
221	Дигидратперфторацетон	2	бх	у	
222	Дилор	0,2	х	у,а	
223	Дидодецилфталат	1	бх	у,а	
224	Диизопрпиламин	5	х	у	
225	Диизопропаноламин	1	х	у,а	хү
226	Диизопрпил бензол (изо, пара)	50	бх	у	хү
227	2, 5 дивинилпиридин	1	х	у	хү
228	Дигидрат перфторацетон	2	бх	у	
229	В-дигидрогептахлор (дилор)	0,2	х	у,а	
230	2,3-Дигидро-5-карбоксиянид-6-метил-1, 4-оксатийн (витавакс)	1	бх	а	хү
231	2, 2-дигидроокси-3, 3, 5, 5, 6, 6-гексахлордифенилметан (гексахлорофен)	0,1	бх	а	хү
232	6, 15-дигидро-5, 9, 14, 18-антразинтетрон (индантрон)	5	х	а	
233	Дидодецилолын эфир d фталийн хүчил (дидодецилфталат)	1	х	у,а	
234	Диизопрпиламин	5	бх	у,а	хү
235	Диизопропаноламин	1	бх	у,а	хү
236	Диизопрпилбензол (изо, пара)	50	х	у	хү
237	0, 0 диизопрпилфосфит	4	х	у,а	
238	Диизопрпилийн эфир	100	х	у	
239	Диизобутилфталат	1	бх	у,а	
240	Диизопрпилтеофосфат аммони	10	бх	а	
241	Дикрезол түүний эфир	0,5	х	у,а	
242	Дикумилметан	5	бх	а	хү
243	0, 0 диметил-S-2-ацетил амино-этилдитиофосфат (амифос)	0,5	х	у,а	хү
244	3, 3 диметилбутан-2-он	20	бх	у	
245	Демитиламинопропионитрил	10	бх	у,а	
246	В, В-диметилакрилийн хүчил	5	бх	у,а	
247	3, 5 деметил-1, 2, 3, 5 тетрагид ротиадиазинтион-2	2	бх	а	

	(тиазон)				
248	Диметилвинилкарбонол (3 метил, 1 бутен-3)	10	бх	у	хү
249	Диметилвинилэтинилкарбонил	0,05	ох	у	
250	Диметилвинилэтинилпарокси-фенилметан	0,6	х	у,а	
251	ДДВФ (0, 0 диметил-2, 2 дихлор-винилфосфат)	0,2	х	у	хү
252	Димер метилцианкарбамат	0,5	х	а	
253	Димер метилциклопентадиен	10	бх	у	
254	Ди-(метакрилоксиэтил)-метилфо-сонат	0,1	х	у	
255	Динацил	20	бх	у,а	хү
256	Диметилдипропилентриамин	1	х	у	хү
257	Диметилийн эфир себацены хүчил (диметилсебоцант)	10	бх	у,а	
258	0,0 диметил-0 (2, 5 дихлор-4-бром-фенол)-тиофосфат (бромофос)	0,5	х	у,а	
259	0,0 диметил-0 (2, 5 дихлор-4-иод-фенол)-тиофосфат (иодафенфос)	0,5	х	у,а	
260	0, 0 диметил-S-(карбэтоксиметил) тиофосфат (метилацетофос)	1	х	у,а	хү
261	0, 0 диметил (4 нитро-3 метилфе-нил) тиофосфат (метилнитрофос)	0,1	ох	у,а	хү
262	0, 0 диметил-0-(4-нитрофенил) тиофосфат (метафос)	0,1	ох	у,а	хү
263	N-N-ди-1, 4-диметилпентил-п-фенилендиамин (сантофлекс-77)	5	бх	у,а	
264	Диметилфосфит	0,5	х	у	хү
265	1, 2-диметоксиэтан	10	бх	у	
266	ДДТ (п-дихлордифенилтри-хлорэтан)	0,1	ох	у,а	
267	N-N-диметил-2, 2-дифенилацета-мед дифениламин	5	бх	у,а	
268	Ди-(3-метилгексил) фталат	1	х	у,а	
269	4, 4-диметилдиоксан-1, 4	10	х	у	
270	Диметилпропандиамин	2	бх	у	хү
271	Диметилийн эфир, хүхрийн хүчилтэй (диметилсульфат)	0,1	ох	у	хү
272	4, 4-диметилдиоксан-1, 3	3	бх	у	
273	Диметилсульфоксид	20	бх	у,а	
274	Диметилсульфид	50	бх	у	хү
275	Диметилцианамид	0,5	ох	у	хү
276	Диметилциклогексиламин	3	бх	у	хү
277	0,0-диметил-0-(4-цианофенил)	0,3	х	у, а	

**MNS 4990 : 2000**

	тиофосфат (цианокс)				
278	2-(диметиламиноэтил)-5-винилпиридин	1	х	а	хү
279	Диметилийн эфир (диметил-фталат)	0,3	х	у, а	
280	Диметиланилин	0,2	х	у	хү
281	Диметиламин	1	х	у	
282	Диметилбензиламин	5	бх	у	
283	Диметилтерефталат	0,1	х	у, а	
284	Диметилформаид	10	х	у	хү
285	N-N-диметил-N-1-хлорфенил гуанидин (ФДН)	0,5	х	у, а	хү
286	0,0-диметил-S-этилмеркаптоэтил-тиофосфат (M-81 экатин)	0,1	ох	у, а	хү
287	Диметилхлортиофосфат	0,5	бх	у	
288	Диметилэтанолламин	5	х	у	хү
289	Дисульфан	1	ох	а	
290	2, 6-диметилфенол	2	бх	у	хү
291	3, 5 динитро-4-хлорбензотрифторид	0,05	ох	у, а	хү
292	Динил (25% дифенил ба 75% дифенилоксид)	10	бх	у, а	
293	Динитробензол	1	х	а	хү
294	4,6-динитро-2 изопропилфенол	0,05	ох	у, а	хү
295	Динитро-о-крезол	0,05	ох	у, а	хү
296	Динитротолуол	1	ох	у, а	хү
297	Динитрил адипиний хүчил	10	бх	а	
298	Динитрил перфторглютарын хүчил	0,05	ох	у	
299	Динитрил перфторадипиний хүчил	0,1	ох	у	
300	Динитроданбензол	2	х	а	хү
301	Динонилийн эфир, фталийн хүчил (динонилфталат)	1	х	у, а	
302	4,4-дитио-(бисфенилмалеимид)	5	бх	а	
303	Дифторхлорэтилен	1	х	у	
304	Динитрилфталат	1	х	у, а	
305	Динитронафталин	1	х	а	
306	3, 5-динитро-4-хлорбензойны хүчил	1	х	а	
307	Диоктилсебацант	1	бх	у	
308	2, 4-динитроанилин	0,3	х	а	
309	2, 4-динитрохлорбензол	0,05	ох	у, а	хү
310	2,4-динитро-2 фторбутилфенол (диносеб)	0,5	ох	у, а	хү
311	2, 6 динитро-N-N-дипропил-4-трифторметиланилин (трефлен)	3	бх	у, а	хү

312	2, 4-динитро-6-(2-октил)-фенил-кротонат(каратан)	0,2	х	а	
313	Ди-и-пропиламин	2	х	у	хү
314	Диоксон 1, 4 (диэтилены 2-ч исэл)	10	бх	а	хү
315	Диспергатор НФ. (динафтил-метандисульфо хүчил ба динафтил-метансульфо хүчлийн натрийн давсны холимог)	2	бх	а	
316	2-(дифенилацетил) индандион-1, 3 (ратиндин, дифенацил)	0,01	ох	а	
317	0, 0 дифенил-1-окси-2, 2, 2-трихло-рэтилфосфонат (оксифосфонат)	1	х	а	
318	Дифенилолпропан	5	бх	а	
319	N-N-дифураль-п-фенилендиамин	2	х	у,а	
320	Дихлорангидрид 2, 3, 5, 6-тетрахлортерефталын хүчил	1	х	а	хү
321	Дихлорметил	0,1	ох	у	
322	3, 4-дихлорпропионанилид (пропа-нид)	0,1	ох	а	
323	Дихлорстирол	50	бх	у	
324	2, 4-дихлортолуол	10	бх	у	хү
325	Дихлорфенилтрихлорсилан	1	х	у	
326	0, 2, 4-дихлорфенил-N-изопропиламинохлорметил-тиофосфонат (изофос-2)	0,5	х	у,а	хү
327	$\alpha$ , $\alpha$ -дихлор- $\alpha$ -фтортолуол	1	х	у	хү
328	Дитразинцитрат (1-метил-4-диэтилкарбамилпиперазин цитрат)	5	бх	а	
329	Дитребултийн хэт исэл	100	бх	у	
330	Дифенил (хлоржуулсан)	1	х	у	хү
331	Дифенилийн хлоржуулсан исэл	0,5	х	у	хү
332	Дифенилоксид	5	бх	у	
333	1, 3-дихлорацетон	0,05	ох	у	
334	3, 4-дихлоранилин	0,5	х	у	хү
335	Дихлорбензол	20	бх	у	хү
336	1, 3 дихлорбутен-2	1	х	у	хү
337	Дихлоргидрин	5	бх	у	
338	1, 2-дихлоризобутан	20	бх	у	
339	1, 3-дихлоризобутилен	0,5	х	у	хү
340	3, 3-дихлоризобутилен	0,3	х	у	хү
341	3,3-дихлорметилоксациклобутан	0,5	х	у	хү
342	2, 3-дихлор-1, 4-нафтахинон	0,5	х	а	
343	3, 4-дихлорнитробензол	1	х	у	хү

**MNS 4990 : 2000**

344	1, 2-дихлорпропан	10	бх	у	
345	1, 3-дихлорпропилен	5	бх	у	
346	2, 3-дихлорпропилен	3	бх	у	
347	1, 10-дикандикарбоны хүчил	10	бх	а	
348	$\alpha$ - $\alpha$ -Дихлорпропионыхүчил	10	бх	у,а	
349	$\alpha$ - $\beta$ -Дихлор- $\beta$ - формилакрилийн хүчил	0,1	х	а	
350	3, 4-дихлорфенилизоцианат	0,3	х	у	хү
351	Дихлоризоцианат	1	х	у	
352	1, 1-дигидрперфторамилийн эфир, акрилийн хүчил	30	бх	у	
353	Дициклопентадиен	1	х	у	хү
354	$\beta$ -Диэтиламиноэтилмеркаптан	1	х	у	хү
355	Диэтиламиноэтилметакрилат	800	бх	у	
356	Диэтилбензол	10	бх	у	
357	Диэтилперфторадипинт	0,1	ох	у	хү
358	Диэтилперфторглютарт	0,1	ох	у	хү
359	Диэтилхлортиофосфат	1	х	у	
360	1,1-дигидроперфторгептилийн эфир акрилын хүчил	30	бх	у	
361	Дифурфурилиден ацетон	10	ох	у,а	хү
362	4, 4-дифенил метан динолцианит	0,5	х	у,а	хү
363	Дифтортетрахлорацетон		бх	у	хү
364	$\beta$ - $\beta$ дихлордиэтилийн эфир (хлорекс)	11	бх	у	
365	Дихлорангидрид 2, 6- нафталин-дикарбоны хүчил	0,5	х	а	
366	1, 4-дихлорбутен-2	0,1	х	у	хү
367	2, 3-дихлорбутадиен-1, 3	0,1	х	у	хү
368	3, 4-дихлорбутен-1	1	х	у	хү
369	Дитолилметан	1	х	у,а	
370	Дициклобутилиден	10	бх	у	хү
371	3, 3-дихлор-бицикло (2, 2, 1)- гепт 5-ен-2-спиро (2, 4, 5- дихлор-4-циклопентан-1, 3- дион) (ЭФ-2)	0,2	х	у,а	
372	2,3-дихлор-5 (дихлорметилен- 2-циклопентенон-1, 4-дион) (дикетон)	0,05	ох	у,а	хү
373	Дихлоральмочевин	5	бх	а	
374	4, 4-дихлордифенилсульфон	10	бх	а	
375	2, 4дихлорфенол-цууны хүчил	1	х	а	
376	Дициклогексиламин (тосонд уусдаг давс) ингибитор- МСДА-11	1	х	а	хү
377	Дициклогексиламина нитрит (ингибитор коррозин НДА)	0,5	х	у	
378	Ди-2-(этилгексил) фенилфосфат	1	х	у	хү



379	Ди-(2-этилгексил) фталат	1	х	у,а	
380	Диэтилт мөнгөн ус	0,005	х	у	
381	Диэтилийн эфир малиены хүчил	1	х	у,а	хү
382	0, 0-диэтил-S-(6 хлорбензок сазолин 3 метил) дитиофосфат, (фозалон)	0,5	х	у	
383	Диэтилэтаноламин	5	бх	у	хү
384	Диэтилэтаноламины давс 2-хлорид-N-(4-метокси-6-метил-1, 3, 5-триазин-2-ил) аминакарбонил-бензолсульфамид (хардин)	5	бх	а	
385	Диприн (уургаар)	0,3	х	а	
386	Додецилгуанидинацетат (мельпрекс, карпен)	0,1	х	а	
387	Додецилмеркаптан (гуравдагч)	5	бх	у	
388	Дефолиант УДМ-П, С, МН	10	бх	а	
389	Дрожж (нүүрс устөрөгч агуулсан) (ВСБ-542, ВСБ-542в, ВСБ-779, ВСБ-777, ВСБ-774, ВСБ-640)	500	х	а	
390	Дихлор цууны хүчил	4	бх	у,а	хү
391	Дистенсиллимант-ИТ	6	бх	а	хү
392	4 хлорт титан	0,3	х	а	
393	Ди-В-хлорэтилийн эфир финил-фосфорын хүчил (винифос)	0,6	х	у,а	хү
394	N,N-диэтил-C <sub>6</sub> C <sub>8</sub> алкилоксамат (оксамат)	5	бх	у,а	
395	Дизоксипеганин гидрохлорид	0,5	х	а	хү
396	N-N-диэтил-N, N-дифенилтиурамид сульфид (тиурам ЭФ)	2	бх	а	
397	Дефолиант "УДМ-П", "С", "МН"	10	бх	а	
398	0, 0-диэтил-0-12-изопропил 4 метил 8-пиримидил-тиофосфат (базудин)	0,2	х	у,а	хү
399	Диэтилтеллурид	0,0005	ох	у	
400	0, 0 диэтилтиофосфорил 0-(d цианбензальдоксим-валексон)	0,1	х	у,а	
401	Диэтилфталат	0,5	х	у,а	
402	Доломитийн давирхай	2	бх	а	
403	Зенкор	0,1	х	у,а	
404	Зэс	1	х	а	
405	Зэсийн исэл	0,1	х	а	
406	Зэсийн хлор ба хүхэрхүчлийн нэгдлүүд	0,5	х	а	
407	Зэс никелийн нэгдлүүд	4	бх	а	
408	Зэсийн фосфид	0,5	х	а	
409	Зэврэлт саатуулагч НДА	0,5	х	а	

**MNS 4990 : 2000**

410	Зэврэлт саатуулагч В-30	2	бх	у	
411	Зоокумарин	0,001	ох	у,а	
412	Зэс хром барийн катализатор	0,1	ох	а	
413	Зэс никелийн хүдэр	4	бх	а	
414	Ингалан (1, 1-дифтор-2, 2-дихлорэтилметилийн эфир)	200	бх	у	
415	Изопрен	40	бх	у	
416	Изоамил бромт	0,5	х	у	хү
417	Изобутилийн эфир метакрилийн хүчил	40	бх	у	
418	Идэмхий шүлт (натрийн шүлтээр)	0,5	х	а	
419	Иод	1	х	у	
420	Иодын исэл	4	бх	а	
421	1-иодгептафторпропан	1000	бх	у	
422	Изоамилийн спирт	5	бх	у	
423	Изобутилийн спирт	10	бх	у	хү
424	Изобутинилкарбинол	10	бх	у	хү
425	Изобутилен	100	бх	у	
426	Изобутилен (хлорт)	0,3	х	у	хү
427	Изовалераны альдегид	10	бх	у	
428	Индийн исэл	4	бх	а	
429	Иттрийн исэл	2	бх	а	
430	Изопропенилацетилен	20	бх	у	
431	0, 0- изопропил –S-бензилтиофос-фат (китацин,рицид-II)	0,3	х	а	
432	3-изоцианит толуол	0,1	ох	у	хү
433	Изопрен олигомер	15	бх	у	
434	Изопропилийн спирт	10	бх	у	
435	Изотосон хүчлийн альдегид	5	бх	у	хү
436	Изопрен	40	бх	у	
437	изопропиламинодифениламин	2	х	а	
438	Изопропилбензол (кумол)	50	бх	у	
439	Изопропилнитрат	5	бх	у	
440	Изопропилнитрит	1	х	у	
441	Изопропилхлоркарбонат	0,1	ох	у	
442	Изопропил, мета-терфенил	5	бх	у,а	
443	Изопропид-N-фенилкарбамат (ИФК)	2	бх	у,а	
444	Изопропил-N-3-хлорфенилкарба-мат (ИФК-хлор)	2	бх	у,а	
445	Изофталын хүчил	0,2	х	а	хү
446	Ипазин (2-хлор-4-диэтиламин-6-изопропиламиносимметриазин)	2	бх	а	
447	Карбоксид	0,5	х	у,а	
448	Крахмал	10	бх	а	
449	Кали иод	10	бх	а	

450	Кальц, кальцийн исэл	3	бх	а	
451	Кальцийн карбид	2	бх	а	
452	Калиперсульфатаммоний	10	бх	а	
453	Калибихроматууд	0,01	ох	а	
454	Кадмин стеарат	0,1	ох	а	
455	Кадмийн исэл	0,1	ох	а	
456	Кадми түүний органик бус нэгдэл	0,05/0,01	бх	а	
457	Кальцжуулсан сод	2	бх	а	хү
458	Камфара	3	бх	а	
459	Капролактамы	10	бх	а	
460	Капрон, капроны хүчил	5	бх	у	
461	Карбамид аммикийн бордоо	25	бх	у,а	
462	Карбатион (метилдитиокарбамаат натри)	0,1	ох	а	хү
463	Карбонат 4, 4 диаминодиоцикло-гексилметан (ингибитор, коррозин В-30)	2	бх	у,а	
464	Коррунд хромын холимогтой коррунд	6	бх	а	
465	Карбофос (0, 0-диметил-S/1, 2 бискарбозетокситэилдитио фосфат)	0,5	х	у,а	хү
466	Карбин 10-(4-хлорбутин-2-ил-3)-N-(3-хлорфенил)	0,5	х	а	
467	Карбокромен (интенсаин интенкордин)	0,3	х	а	
468	Карбоксиметилцеллюлозын натрийн давс	10	бх	а	
469	Керосин	300	бх	у	
470	Кобальт (металл) ба кобальтын исэл	0,5	х	а	
471	Кобальтын гидрокарбонил ба түүний задралын бүтээгдэхүүн	0,01	ох	у	
472	Которан (N-3-трифторметилфенил-N, N-диметилмочевин)	5	бх	а	
473	Кофейн үндэс	0,5	х	а	
474	Ксилоглюканофоетидин (Пх, ПЗх) (П10х, П20х)	2 4	бх бх	а а	
475	м, п-Крезол, дикрезол	0,5	х	у	хү
476	Керамик (шавар бүтээгдэхүүний тоос)	2	бх	а	
477	Коротоны альдегид	0,5	х	у	хү
478	Ксантогенат бутилын кали	10	бх	а	
479	Ксантогенат кали изобутилийн, изоамилийн, изопропилийн	1	х	а	хү

**MNS 4990 : 2000**

480	Ксантогенат этилийн кали	0,5	х	а	хү
481	Каллиод уусмал (цахиурын хүчил ба хайлуур цахиурын холимогийн)	1	бх	а	
482	Ксилидин	3	бх	у	хү
483	Ксилол	50	бх	у	
484	Купроцин	0,5	х	а	
485	Лавсан	5	бх	а	
486	Лигроин	300	бх	у	
487	Левомоцитин	1	х	а	
488	Лизин (талст)	5	бх	а	
489	Лупинин	0,2	х	у,а	хү
490	Ленкомицин гидрохлорид моногид-рат	0,5	х	а	
491	Люминофор ЛФ-490-1	4	бх	а	
492	Люминофор (иттрийн исэл дээр суурилагдсан) К-77	2	бх	а	
493	Люминофор К-83, 82, Р-540у, КТБ, Б-3-Ж	0,1	х	а	
494	Люминофор К-82-Н, К-75, ЭЛС-580-В, ЭЛС-510-В, ЭЛС-455-В	5	бх	а	
495	Люминофор К-86 (цайрын исэлд суурилагдсан)	2	бх	а	
496	Люминофор Л-3500-III, ЛФ-630-1, ЛЦ-6200-1, ЛФ-6500-1	6	бх	а	
497	Люминофор ФЛД-605, ЛК-6200-1, ЛР-1	6	бх	а	
498	Магнит зэс	6	бх	а	
499	Магнезит	10	бх	а	
500	Магнит кали	5	бх	а	
501	Магнит хөнгөн цагаан	6	бх	а	
502	Магнит цайр	6	бх	а	
503	Манеб (этилен –N, N-бисдитиокар-бамат-марганц)	0,5	х	у	
504	Магний исэл	10	бх	а	
505	Марганцын органик биш нэгдлүүд	0,3	х	а	
506	Марганц хүчлийн кали	0,2	х	а	
507	Магнат зэс	6	бх	а	
508	Магнат кали	5	бх	а	
509	Марганц түүний исэл: а. аэрозольдезинтеграц б. аэрозольконденсаци	0,3 0,05	х ох	а а	
510	Мезидин (2-амин, 3-5-триметил бензол)	1	х	а	
511	Малеины ангидрид	1	х	у,а	хү
512	Мезитилийн исэл (изопронилиде-нацетон)	1	бх	у	хү
513	Меламин	0,5	х	а	
514	Меркаптофос (тионы хольц,	0,02	ох	у,а	хү

	тиолын төрлүүд, 0, 0-диэтил, В-этилмеркапоэтилтиофосфат				
515	Меркуран (этилмеркурхлоридын хольц гексахлорциклоны төрлүүд)	0,005	ох	у,а	хү
516	Метакрилийн хүчил	10	бх	у	
517	Метакрилийн ангидрид, метакри-лийн амид	1	х	у	
518	Метан	2	бх	у,а	
519	Метилацетат	100	бх	у	
520	Метилаль	10	бх	а	
521	Метилацетилен-аллены фракц	135	бх	у	
522	2-метил-4-амино-5-этоксиметил пиримидин (аминопиримидин)	1	х	у,а	
523	Метил-N-(2-бензимидазолил) карбамат (БМК)	0,1	х	а	
524	Метилийн эфир	2	бх	у,а	
525	Метилийн эфир, метоксицууны хүчилтэй	1	х	у	
526	Метилмеркаптофос	0,1	ох	у,а	хү
527	1-метилнафталин, 2-метилнафта-лин	20	бх	у	
528	N-метилморфолин	5	бх	у	хү
529	α-Метилстриол	5	бх	у	
530	Метилийн эфир, акрилийн хүчилтэй	5	бх	у	
531	Метилийн эфир, метакрилийн хүчилтэй	5	бх	у	
532	Метилийн эфир, валерины хүчилтэй	1	х	у	хү
533	Метилийн эфир, изовалерины хүчилтэй	5	бх	у	хү
534	Метилийн эфир, изотосон хүчилтэй	10	бх	у	хү
535	Метилийн эфир, пропины хүчилтэй	10	бх	у	
536	Метилийн эфир, п-толуолын хүчилтэй	10	бх	у	
537	Метилийн эфир, капроны хүчилтэй	1	бх	у	хү
538	Метилийн эфир, тосны хүчилтэй	5	бх	у	
539	Метилийн эфир, нитро цууны хүчилтэй	2	бх	у,а	хү
540	N-метилпирролидон	100	бх	у,а	
541	Метилпропилкетон	200	бх	у	
542	Метилфторфенилдихлорсила н	1	х	у	хү
543	Метилхлорацетат	5	бх	у	

**MNS 4990 : 2000**

544	Метилхлорформ (1, 1-трихлорэтан)	20	бх	у	
545	Метилциклогексан	50	бх	у	
546	Метилэтилкетон	200	бх	у	
547	0-метил-0- этилхлортиофосфат	0,3	х	у	
548	2-метил-5-этилпиридин	2	бх	у	хү
549	Метилэтилтиофос (0-метил-0- этил-нитрофенилтиофосфат)	0,03	ох	у,а	хү
550	Метилаллилхлорид	0,3	х	у	хү
551	2-метил-5-винилпиридин	2	бх	у	хү
552	6-метил-2-винилпиридин	0,5	х	у	хү
553	Метилгексилкетон	200	бх	у	
554	Метилвинилкетон	0,1	ох	у	хү
555	Метилтиофен (2, 3 баз төрлүүд)	20	бх	у	
556	Метилдигидропиран	5	бх	у	хү
557	Метилизобутилкарбонил (2-метил-пентанол-2)	10	бх	у	хү
558	Метилизотиоцианат	0,1	ох	у	хү
559	Метилизоцианат	0,05	ох	у	хү
560	0-метиланизол	10	бх	у	
561	5-метилбензотриазол	5	бх	у,а	
562	Метионин	5	бх	а	
563	Метилтестостерон	0,005	ох	а	
564	Метилциклопропилкетон	1	х	у	
565	Метилизобутилкетон	5	бх	у	хү
566	2-метокси-3, 6- дихлорбензойны хү-чил	1	х	а	
567	3-метоксикарбамидфинил-N- 3-фенил метил карбамат (фен-медифам)	2	бх	а	
568	Пара метиланизол	10	бх	у	
569	Метилен мочевин	10	бх	а	
570	1-метил-2-изопропилбензол (орто-цилом)	10	бх	у	
571	Метилентетрагидропиран	50	бх	у	хү
572	Метил 3-дагч бутилийн эфир	100	бх	у	
573	3-метил-4-тиометилфенол	2	бх	у,а	хү
574	1-метил-2 (3-пиридил)- пирроли-динсульфат (никотин сульфат)	0,1	ох	у,а	
